



**ДОРНОД АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Баянтумэнтэйн гудамж, 9 дугээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-3040, факс: 7058-4681  
Цахим шуудан: [azdg@dornod.gov.mn](mailto:azdg@dornod.gov.mn)  
Цахим худас: [Dornod.gov.mn](http://Dornod.gov.mn)

дэлгүүр 04.30 № 5/1095

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

**Г СУМЫН ЗАСАГ ДАРГА НАРТ**

“Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинэчлэн батлахтай холбогдуулан нэлвөллийн шинжилгээ хийх, тогтоолын төслийг болсовруулах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/146 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.

Иймд тогтоолын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийсэн танилцуултыг сумын мэдээллийн албан ёсны цахим хаяг байршуулан олон нийт, малчин, мал бүхий иргэд, малын эмч нараар хэлэлцүүлэн гарсан саналыг хурлын тэмдэглэлээр албажуулан 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр ирүүлнэ үү.

Хавсралт: 4 хуудастай



**БУС, ОРОН НҮТГИЙН ХӨРӨНГО  
ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТНИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА** *[Signature]* Н.ГЭРЭЛЦЭЦЭГ

21159990541

2025.04.30-нд тоотыг цахим шуудангаар хүрүүлэв.

/My Computer D/ A5-toot

Төсөл

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВЫГ ШИНЭЧЛЭН  
БАТЛАХ ТУХАЙ ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛД  
ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025.04.14

Чойбалсан хот

**1. Акт гарах үндэслэл, шаардлага, зорилт**

а/ Акт гаргах үндэслэл:

- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг аймгийн мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн батална гэж заасан.

б/ Акт гаргах шаардлага:

- Малын гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд улсын төсөв, орон нутгийн төсөв болон малчин, иргэдийн өөрийн санхүүжилтээр үйлчилгээ хийгдэж байгаа ч үйлчилгээний нэгжийн өртөг нь 2012 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн баталсан нормативын дагуу явж ирсэн нь мал, амьтны эрүүл, мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжид сэргөөр нөлөөлж байна.

Энэ нь манай салбарын хувьд ч сэргөөр нөлөөлж хувийн аж ахуй нэгжид ажиллаж буй малын эмч нарын орлогын эх үүсвэр болсон ажил үйлчилгээний тарифийг шинэчлэн батлах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Иймд 2012 онд батлагдсан мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний үнэ тариф нь одоогийн бодит нөхцөл байдалд тохирохгүй байгаа бөгөөд эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд муу байх тул “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив”-ыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шинэчлэн батлуулах шаардлага бий болсон.

в/ Акт гаргах зорилт

“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив”-ыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шинэчлэн батлуулснаар мал, амьтны эрүүл, мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ, мөн мал эмнэлгийн салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын малын эмч нарын эрх зүйн байдал сайжирч, иргэдэд үйлчилж байгаа үйлчилгээний зардлын норматив одоогийн нөхцөл байдал, эдийн засаг үзүүлэх үр нөлөө нь бодит болно.

**2. Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

а/ Ерөнхий бүтэц:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив” нь 4 бүлэг, 7 зүйл заалттай байна.

б/Зохицуулах харилцаа

- Дорнод аймгийн хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхдээ мөрдөх зардлын норматив хэм хэмжээг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

в/ Хамрах хүрээ

- Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллага, малчин, мал бүхий иргэд, тухайн үйлчилгээтэй холбоотой төсвийг шийдвэрлэж байгаа төрийн байгууллагууд нь энэхүү зардлын нормативтай холбогдсон харилцааны оролцогч болно.

**3. Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийн хувьд:**

Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллага, малчин, мал бүхий иргэд, тухайн үйлчилгээтэй холбоотой төсвийг шийдвэрлэж байгаа төрийн байгууллагуудын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөр байна.

Иймд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив”-ыг аймгийн иргэд, олон нийтэд танилцах, санал авах шаардлагатай байна. Мөн Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагын төлөөлөл, иргэдийг оролцуулан аймгийн 14 сумын хэмжээнд хэлэлцүүлэг хийх шаардлагатай байна.

**4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх.**

№	Нөлөөллийн шинжилгээний нөхцөл байдал	Нөлөөллийн шинжилгээний дүгнэлт
1	Ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Актад ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн заалт байхгүй болно.
2	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулж байгаа эсэх, хэрэв тийм бол хуульд нийцсэн эсэх.	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй болно.
3	Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Жендерийн эрх тэгш байдлыг хөндсөн агуулсан ямар нэгэн заалт ороогүй ба төлбөрийн хэмжээ тогтоосон актад жендерийн тэгш байдал хамаарахгүй болно.
4	Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болох эсэх.	Тус тогтоолд Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нөлөөлсөн заалт агуулагдаагүй болно.
5	Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болох эсэх	Үнийн хөөрөгдөл үүсгэх ямар нэгэн заалт агуулаагүй бөгөөд мал эмнэлгийн үйлчилгээний зардлын

		норматив батлах эрх нь хуулиар иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд хадгалагдана.
6	Аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл	Аж ахуй нэгжид бэрхшээл болох заалт агуулаагүй болно.
7	Төрийн байгууллага болон бусад, иргэн хуулийн этгээдийн захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болох эсэх	Төрийн байгууллага болон бусад, иргэн хуулийн этгээдийн захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал үүсэхгүй.
8	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хургэх эсэх	Ийм төрлийн заалт агуулаагүй болно.
9	Эдийн засаг нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх	Ийм төрлийн заалт агуулаагүй болно.
10	Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлсөн ямар нэгэн заалт агуулаагүй болно.
11	Хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх байгаа бол тэр нь хуульд нийцсэн байх.	Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно.

##### 5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор “Мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээний нэр төрөл, үнийн жагсаалт/тариф”-ыг баталсан боловч эдийн засагт үзүүлэх нөлөөлөл болон цаг хугацааны хувьд ач холбогдолгүй муу байх тул дахин шинэчлэн гаргах шаардлагатай байгаа болно.

##### 6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо:

Аймгийн хэмжээнд 14 суманд 50 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 105 малын эмч ажиллаж байна. Хэлэлцүүлгийн явцад Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарын гаргасан санал нь бод малд 1000, бог 500, гахай нохой 1000 төгрөг байхаар, Малчид бод мал 1200, бог мал 500, гахай нохой 1000 төгрөг байхаар санал гаргасныг Мал эмнэлгийн газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлгээс гарсан санал, аймгуудын баталсан үнэ тарифтай харьцуулалт хийж Бод мал 1000, бог мал 500, амьтан (нохой, гахай, муур)-д 1000 төгрөг байхаар төслийг боловсруулсан.

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ МАЛ  
ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ**

№	Үйлчилгээний нэр, төрөл	Малын төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ /Төгрөг/
<b>1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх</b>				
1.1	Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын өвчинүүдээс сэргийлэх тарилга /1.1-ээс бусад/	Бод /Тэмээ, адuu, үхэр, сарлаг/	Толгой	1,000
		Бог /Хонь, ямаа/	Толгой	500
		Амьтан /Гахай, нохой, муур/	Толгой	1,000
<b>2. Мал, амьтны эрүүл мэндийн үзлэг хийх</b>				
2.1	Халдварт өвчний анхны онош тогтоох үзлэг	Бод, бог, амьтан	Толгой	600
<b>3. Мал, амьтны өвчний шинжилгээнд сорьц авах</b>				
3.1	Цусны сорьц	Тэмээ, үхэр, адuu	Толгой	2,500
		Хонь, ямаа	Толгой	1,500
		Гахай	Толгой	1,500
3.2	Эд, эрхтний сорьц /нядалж болон хүүр, сэг зэмийг задалж/	Бод /тэмээ, адuu, үхэр, сарлаг/	Толгой	12,000
		Хонь, ямаа	Толгой	9,000
<b>4. Ариутгал, халдвартгүйтгэл</b>				
4.1	Өвчний голомтыг устгах ариутгал, халдвартгүйтгэл	Бүгд	M <sup>2</sup>	300

---оо---